



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэрийн, нийт 444,048.31 (дөрвөн зуун дөчин дөрвөн мянга дөчин найман доллар гучин нэгэн цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин Сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Сэлбэгээр худалдсан тээврийн хэрэгслээс олох орлогыг зохих журмын дагуу улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001468

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, худалдах хөрөнгийн жагсаалт

№	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил
1	D146003 дугаартай, микроавтобус, арлын дугаар SL6196742	2012/2012.08	172758	32,730.00	3,000.00	Гавана ЭСЯ
2	Ланд Крузер 200 маркийн суудлын автомашин, H-0099 дугаартай, арлын дугаар JIMCV091904140485	2014/2014.01	160447	65,669.01	2,000.00	Эрээн КГ
3	Тоёото Хайс маркийн микроавтобус, NG80-381-03 дугаартай, арлын дугаар RL4RX12P289001811	2008/2009.01	95000	30,300.00	3,000.00	Ханой ЭСЯ
4	Mercedes маркийн суудлын автомашин, CD-3915 дугаартай, арлын дугаар WDD2120472A680422	2012/2012.10	100669	72,268.55	2,000.00	Сингапур ЭСЯ
5	HYUNDAI STAREX маркийн микроавтобус, ДК 34-04 дугаартай, Арлын дугаар - KMJWAN7JP8U075315	2008/2008	210000	28,600.00	3,000.00	Вьентьян ЭСЯ
6	Chevrolet Cruze маркийн суудлын автомашин, CD 06-213 дугаартай, Арлын дугаар - KLIRI5CSIAХ758846	2010/2010.12	135000	15,806.00	1,500.00	Эль Кувэйт ЭСЯ
7	Peugeot 508 SW суудлын автомашин, 34CC-2297 дугаартай, Арлын дугаар - VF38E9HD8DL034858	2013/2014.05	124242	25,701.95	2,000.00	Истанбул ЕКГ
8	Mercedes Benz маркийн, суудлын автомашин, 34CC-2423 дугаартай, Арлын дугаар - WDD2120341B132745	2014/2015.01	126284	58,308.67	2,000.00	Истанбул ЕКГ
9	Ланд круйзер 200 маркийн суудлын автомашин, Dip-2710 дугаартай, Арлын дугаар - JTMH05J704039385	2013/2013.01	266448	80,490.61	2,000.00	Кызыл ЕКГ
10	Volkswagen Caravelle маркийн микробус, CD001LL дугаартай, Арлын дугаар-WV2ZZZ7HZCH057498	2011/2012.03	177587	34,173.52	3,000.00	Ром ЭСЯ
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			444,048.31 (дөрвөн зуун дөчин дөрвөн мянга дөчин найман доллар гучин нэгэн цент)	23,500.00 (хорин гурван мянга таван зуун ам доллар)	